



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/88

Хэрлэн сум

Тээврийн хэрэгслийн татвар хураалт,
техникийн хяналтын үзлэг явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.10, Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 7 дугаар зүйлийн 7.1, Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 17 дугаар зүйлийн 17.1, 17.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд авто тээврийн хэрэгслийн татвар хураалтыг 2023 оны 6 дугаар сарын 01-ний дотор, техникийн хяналтын үзлэгийг жилийн туршид зохион байгуулсугай

2. Дээрх ажлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга:	Л.Батсайхан	Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Ц.Бат-Эрдэнэ	Аймгийн Авто тээврийн төвийн дарга
Гишүүд:	Э.Мөнх Эрдэнэ	Аймгийн Засаг даргын Тамгын газрын хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
	А.Гантөмөр	Аймгийн Татварын хэлтсийн дарга
	Л.Мэндбаяр	Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга
	Д.Батхүү	Аймгийн Цагдаагийн газрын дарга, хурандаа

3. Сумдад авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг явуулах хуваарийг 1 дүгээр, ажлын удирдамжийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

4. Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн өмнө тээврийн хэрэгслийн албан татварыг хураан авч, өөрийн нутаг дэвсгэрт байгаа бүх тээврийн хэрэгслийг бүртгэл судалгааны дагуу үзлэгт бүрэн хамруулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2.

5. Батлагдсан хуваарийн дагуу явагдсан авто тээврийн хэрэгслийн татвар хураалт, техникийн хяналтын үзлэгт ороогүй тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцохыг хориглон, зөрчил арилгуулах арга хэмжээ авч ажиллахыг Цагдаагийн газрын дарга (хурандаа Д.Батхүү)-д, техникийн хяналтын үзлэгээс хоцорсон тээврийн хэрэгслийг техникийн үзлэгт тухай бүрт нөхөн оруулахыг Авто тээврийн төвийн дарга (Ц.Бат-Эрдэнэ)-д тус тус үүрэг болгосугай.

6. Тээврийн хэрэгслийн татвар хураалт, техникийн хяналтын үзлэгийн үйл ажиллагааг хагас бүтэн жилээр дүгнэн, дүнг танилцуулахыг Комиссын дарга (Л.Батсайхан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 13-ны дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

ХЭНТИЙ АЙМГИЙН АВТОТЭЭВРИЙН ОРОН НУТАГТ
ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГИЙГ ЯВУУЛАХ ХУВААРЬ

№	Сумдууд	Явах хоног	сар өдөр	Ажлын бүрэлдэхүүн
1.	Галшар	2	4 сарын 24-25	
	Дархан	2	4 сарын 26-27	
	Баянмөнх	2	4 сарын 28-29	
	Хэрлэнбаян-Улаан	1	4 сарын 30	
	Дэлгэрхаан	2	5 сарын 1-2	
	Цэнхэрмандал	3	5 сарын 3-5	
	Хэрлэн сум	5	5 сарын 8-12	
2.	Баянхутаг	2	5 сарын 15-16	Техникийн хяналтын үзлэгийн инженер Б.Баярмагнай
	Мөрөн	2	5 сарын 17-18	
	Өлзийт	1	5 сарын 19	
	Жаргалтхаан	3	5 сарын 22-24	
	Өмнөдэлгэр	7	5 сарын 25-31	
	Хэрлэн сум	5	6 сарын 5-9	
3	Хурх	1	6 сарын 12	Техникийн хяналтын үзлэгийн Техникч С.Наранхүү
	Батширээт	2	6 сарын 13-14	
	Биндэр	4	6 сарын 15-18	
	Баян-Адарга	3	6 сарын 19-21	
	Дадал	2	6 сарын 22-23	
	Норовлин	2	6 сарын 24-25	
	Хэрлэн сум	5	6 сарын 26-30	
4	Батноров	3	7 сарын 3-5	
	Бэрх	2	7 сарын 6-7	
	Тахилгат	1	7 сарын 17	
	Бор-Өндөр УБҮ	1	7 сарын 18	
	Бор-Өндөр	6	7 сарын 19-24	
	Баян-Овоо	2	8 сарын 7-8	
	Орон нутагт	56		